



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/173

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч-Өвөрхангай 2020” хөтөлбөрийн 3.3.4.4-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн биеийн тамирыг дэмжих, аймгийн гар бөмбөгийн шигшээ багийг бэлтгэлийн зал, танхимаар хангах үйл ажиллагааг Багийн нэгдсэн төвийн хажууд байрлах “Ялалт” спорт залтай хамтран гэрээ байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир спортын газар (Б.Энхтөр)-д даалгасугай.

2. Гэрээний төлбөр 5.000.000 (таван сая) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100330